



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 337

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Онцгой байдлын газарт аймгийн Засаг дарга болон Сайншанд сумын Засаг даргын шийдвэрээр тус тус давхардуулан олгосон 300 м.кв талбайтай 4,800,000.00 /дөрвөн сая найман зуун мянга/ төгрөгийн үнэ бүхий биет бус хөрөнгө-газар эзэмших эрхийг данснаас хасч, залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Бригадын генерал Г.Ариунбуян, Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын дарга хурандаа Г.Бат-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Наангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НААНГЭРЭЛ